**Барилга, хот байгуулалтын яам болон түүний харъяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлтийн агуулга** /хувиар/

/2020 оны эхний хагас жилийн байдлаар/

| № | Байгууллагын нэр | Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/ |
|---|---|---|
| 1 | Барилга, хот байгуулалтын яам | Нийт 1255 өргөдлөөс<br>1. Хүсэлт 1205 / 96 %<br>2. Гомдол 47 / 3,7 %<br>3. Санал 3 / 0,2 %<br><br>1. Газрын маргаан, тусгай хэрэгцээнд авсан газрын асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлт 205 / 16,3 %<br>2. Орон сууцны ашиглалт, СӨХ-ийн үйл ажиллагаа, орон сууц худалдаж авах гэрээтэй холбоотой асуудал 190 / 15,1 %<br><br>“150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийг батлуулж, ард иргэдийн худалдан авах чадвар, цаг уурын нөхцөлд нийцсэн, эрүүл аюулгүй, инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангах, орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган ажиллаж байна.<br>Барилгын материалын үнийн өсөлт, тэр дундаа цементийн үнийн өсөлтийн талаар иргэд аж ахуйн нэгжүүд ихээхэн гомдол, санал хүсэлт гаргасан байна. Салбарын яамнаас үүсээд байгаа нөхцөл байдлыг шийдвэрлэх, гарц, боломжийг бий болгохоор холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллахын зэрэгцээ импортын цементийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас цар тахлын үед түр чөлөөлөх, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 95 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.<br>Цементийн үнийн өсөлтийг судлан шийдвэрлэх ажлын хүрээнд салбарын яамнаас холбогдох байгууллагуудыг хамруулсан удаа дараагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, үүсээд буй нөхцөл байдлын шалтгааныг судласнаар 2 үйлдвэрийн ажиллах хүчний квот авах хүсэлтийг Засгийн газар, Улсын онцгой комисст, вагоны хүртээмжийг нэмэгдүүлэх талаар “Улаанбаатар төмөр зам” ХХН-т, эрчим хүчний тарифыг хуулинд нийцүүлэн тогтоох хүсэлтийг Эрчим хүчний сайд, Эрчим хүчний зохицуулах хороо, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д, цемент борлуулалтад хяналт тавьж хамтран ажиллах хүсэлтийг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна. |

**Барилга, хот байгуулалтын яам болон түүний харъяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал**
**/2020 оны эхний хагас жилийн байдлаар/**

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо | Нийт шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | Үүнээс | | Хугацаа болоогүй | Шийдвэрлэлт /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | | |
| 1 | **БХБЯ** | 100 | 93 | 4 | 0 | 3 | 93% |
| 2 | **ГЗБГЗЗГ** | 180 | 175 | 0 | 5 | 0 | 97% |
| 3 | **БХТ ТӨААТҮГ** | 773 | 750 | 0 | 0 | 23 | 97% |
| 4 | **ТОСК ТӨХК** | 202 | 187 | 0 | 2 | 13 | 92% |
| **Дүн** | | **1255** | **1205** | **4** | **7** | **39** | **96%** |

**Барилга, хот байгуулалтын яам болон түүний харъяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт хэлбэрээр**
**/2020 оны эхний хагас жилийн байдлаар/**

| № | Байгууллагын нэр | Нийт өргөдөл, гомдол, санал хүсэлт | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| 1 | **БХБЯ** | 100 | 80 | 20 | - | - | - |
| 2 | **ГЗБГЗЗГ** | 180 | 165 | 15 | - | - | - |
| 3 | **БХТ ТӨААТҮГ** | 773 | 773 | - | - | - | - |
| 4 | **ТОСК ТӨХК** | 202 | 202 | - | - | - | **-** |
| **Дүн** | | **1255** | **1220** | **35** | **-** | **-** | **-** |